



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/491

Улаанбаатар хот

**Оноосон нэрийн өөрчлөлтийг
бүртгэх тухай**

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.9.3 дах заалт, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 416 дугаар тушаал болон “Фингейт секьюритис ҮЦК” ХХК-ийн 2026 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 14 тоот албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХХК-ийн гишүүн “БАТС ҮЦК” ХХК-ийн оноосон нэрийг “Фингейт секьюритис ҮЦК” ХХК болгон өөрчлөн бүртгэсүгэй.
2. Компанийн оноосон нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан системд зохих өөрчлөлтийг оруулж бүртгэхийг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т, олон нийтэд мэдээлэхийг Бизнес хөгжлийн газар (А.Мөнхбаясгалан)-т тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын албаны мэргэжилтэн Ч.Эрдэнэболорт тус тус даалгасугай.

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**



Т.ХАШ-ЭРДЭНЭ

1525031026